

Российская академия наук  
Институт восточных рукописей  
(Азиатский Музей)



Адрес учредителя: 191186,  
г. Санкт-Петербург,  
Дворцовая наб., д. 18.  
Адрес редакции: 191186,  
г. Санкт-Петербург,  
Дворцовая наб., д. 18.  
Адрес издателя: 191186,  
Санкт-Петербург, д. 18.  
Тел.: +7 (812) 315-87-28  
<http://orientalstudies.ru>  
[mongolica@orientalstudies.ru](mailto:mongolica@orientalstudies.ru)  
[kulgan@inbox.ru](mailto:kulgan@inbox.ru)  
[dnosov@mail.ru](mailto:dnosov@mail.ru)

Регистрационный номер  
свидетельства о регистрации  
средства массовой информации  
ПИ № ФС77-79202  
от 22 сентября 2020 г.

Номер подготовлен  
при финансовой поддержке  
РНФ и Кабинета Министров  
Республики Татарстан (проект  
№ 23-28-10046) в соответствии  
с Программой стратегического  
академического лидерства  
Казанского (Приволжского)  
федерального университета.

ISSN 2311-5939

DOI 10.48612/IVRRAN/ambb-3d27-kev9

# MONGOLICA

Санкт-Петербургский журнал монголоведных исследований

Том XXVII • 2024 • № 3

Выходит 4 раза в год

Издается с 1986 г.

Учредитель: ФГБУН

Институт восточных рукописей РАН

Посвящается 300-летию Российской академии наук

## Редакционная коллегия:

- И. В. Кульганек, *главный редактор, доктор филологических наук (Россия)*  
Д. А. Носов, *секретарь редколлегии, кандидат филологических наук (Россия)*  
М. А. Козинцев, *помощник секретаря (Россия)*  
Г. Билгуудэй, *доктор филологических наук (Монголия)*  
А. Бирталан, *доктор наук (Венгрия)*  
Р. М. Валеев, *доктор исторических наук (Россия)*  
Л. С. Дампилова, *доктор филологических наук (Россия)*  
И. В. Зайцев, *доктор исторических наук, профессор РАН (Россия)*  
Ж. Легран, *доктор наук, профессор (Франция)*  
В. Капишовска, *доктор наук (Чехия)*  
Э. Мунхцэцэг, *кандидат филологических наук (Монголия)*  
С. Л. Невелева, *доктор филологических наук (Россия)*  
К. В. Орлова, *доктор исторических наук (Россия)*  
М. П. Петрова, *кандидат филологических наук (Россия)*  
Р. Поп, *доктор наук (Румыния)*  
Ц. Саранцацрал, *доктор филологических наук (Монголия)*  
Т. Д. Скрынникова, *доктор исторических наук, профессор (Россия)*  
С. Чулуун, *академик МАН (Монголия)*  
Е. Э. Хабунова, *доктор филологических наук (Россия)*  
Н. Хишигт, *кандидат исторических наук (Монголия)*  
Н. С. Яхонтова, *кандидат филологических наук (Россия)*

Оригинал-макет – М. В. Алексеева

Литературные редакторы и корректоры – Д. А. Носов, И. В. Кульганек

Технический редактор – М. А. Козинцев

Подписано в печать 11.09.2024

Формат 60×90 1/8. Объем 10 печ. л. Заказ №

Тираж 300 экз.

Отпечатано в типографии ООО «Литография Принт».

Адрес типографии: 191119, Санкт-Петербург, ул. Днепропетровская, д. 8,  
лит. А, офис 14.

*e-mail*: [info@litobook.ru](mailto:info@litobook.ru)

12+

© Институт восточных рукописей РАН  
(Азиатский Музей), 2024

© Коллектив авторов, 2024

## **В НОМЕРЕ:**

### **ИСТОРИЯ, ИСТОРИОГРАФИЯ, ИСТОЧНИКОВЕДЕНИЕ**

- Э. Гансүх.** Монгол данжуур сударт буй тэнгэр, газрын орны язгуурт морийг шинжин таних, дүрслэлийг тодорхойлох нь ..... 5
- Т. Д. Скрынникова.** Орда-Эджен — верховный правитель улуса Джучи ..... 15
- М. В. Федорова.** Коллекции Ц. Ж. Жамцарано в собрании Российского этнографического музея ..... 21

### **ФИЛОЛОГИЯ**

- К. В. Алексеев.** О двух версиях «Артхавистара-сутры» в монгольском Ганджуре ..... 35
- И. А. Алимов.** «Дун цзин мэн хуа лу»: предисловие ..... 44

### **ИЗ АРХИВОВ ВОСТОКОВЕДОВ**

- Лю Лицю, Рамиль М. Валеев, Рафаэль М. Валеев, Р. З. Валеева, С. А. Кириллина.** Неопубликованные письма В. А. Гордлевского академику В. В. Бартольду 1910–1920-х годов из фонда СПбФ АРАН ..... 50
- А. Мандирмаа.** Монголоведение в восточном институте: некоторые архивные документы ..... 64

### **СМЕЖНЫЕ ДИСЦИПЛИНЫ**

- Е. В. Асалханова.** I Международный российско-монгольский пленэр «Рисунок на Ононе» ..... 73
- К. А. Бекетов, Н. К. Бекетова, Х. Дамдинсурэн.** «Дорогами Н. К. Рериха»: экспедиция Санкт-петербургской академии художеств имени Ильи Репина в Монголию (продолжение) ..... 82

### **НАУЧНАЯ ЖИЗНЬ**

- Е. В. Асалханова.** Межрегиональная научно-практическая конференция «Бурятский героический эпос „Гэсэр“. Из прошлого в будущее» (п. Усть-Ордынский, Иркутская область, 17 мая 2024 г.) ..... 104
- Т. В. Ермакова.** Конференция «Актуальные проблемы буддологических и индологических исследований–16» (Санкт-Петербург, 25 марта 2024 г.) ..... 114

RUSSIAN ACADEMY OF SCIENCES  
Institute of Oriental Manuscripts  
(Asiatic Museum)



191186, Russian Federation  
Saint Petersburg,  
Dvortsovaya Emb., 18  
Phone: +7 (812) 315-87-28  
<http://orientalstudies.ru>  
[mongolica@orientalstudies.ru](mailto:mongolica@orientalstudies.ru)  
[kulgan@inbox.ru](mailto:kulgan@inbox.ru)  
[dnosov@mail.ru](mailto:dnosov@mail.ru)

# MONGOLICA

Saint Petersburg journal for Mongolian studies

Vol. XXVII • 2024 • No. 2

The journal is published four times a year.

Published since 1986

Founder: Federal State Institution of Science  
Institute of Oriental Manuscripts of the Russian Academy  
of Sciences

**Dedicated to the 300th anniversary  
of the Russian Academy of Sciences**

## Editorial board:

- I. V. Kulganek — *editor-in-chief, D. Sc. (Philology), Russian Federation*  
D. A. Nosov — *secretary, Cand. Sc. (Philology), Russian Federation*  
M. A. Kozintcev — *assistant secretary, Russian Federation*  
G. Bilguudei. *D. Sc. (Philology), Mongolia*  
A. Birtalan. *Ph. D., Hungary*  
S. Chuluun. *Academician of the Mongolian Academy of Sciences, Mongolia*  
L. S. Dampilova. *D. Sc. (Philology), Russian Federation*  
J. Legrand. *D. Sc., Professor, France*  
V. Kapishovska. *Ph. D., Czech Republic*  
E. E. Khabunova. *D. Sc. (Philology), Russian Federation*  
N. Khishigt. *Ph. D. (History), Mongolia*  
E. Munkhtsetseg. *Cand.Sc. (Philology), Mongolia*  
S. L. Neveleva. *D. Sc. (Philology), Russian Federation*  
K. V. Orlova. *D. Sc. (History), Russian Federation*  
M. P. Petrova. *Ph. D. (Philology), Russian Federation*  
R. Pop. *Ph. D., Romania*  
Ts. Sarantsatsral. *D. Sc. (Philology) Mongolia*  
T. D. Skrynnikova. *D. Sc. (History), Russian Federation*  
R. M. Valeev. *D. Sc. (History), Russian Federation*  
N. S. Yakhontova. *Cand. Sc. (Philology), Russian Federation*  
I. V. Zaytsev. *D. Sc. (History), Professor of the Russian Academy of Sciences, Russian Federation*

ISSN 2311-5939

DOI 10.48612/IVRRAN/ambb-3d27-kevr

© Institute of Oriental Manuscripts RAS  
(Asiatic Museum), 2024  
© Group of authors, 2024

## IN THIS ISSUE:

### HISTORIOGRAPHY. SOURCE STUDIES. HISTORY

- Enkhtaivany Gansukh.** Characteristics and Descriptions of Sky and Land-derived Horses in Danjuur Sutra..... 5
- Tatiana D. Skrynnikova.** Orda-Ejen — the Supreme Ruler of Juchi Ulus ..... 15
- Marina V. Fedorova.** Collections of Tsyben Zhamtsarano in the Russian Museum of Ethnography ..... 21

### STUDIES IN PHILOLOGY

- Kirill V. Alekseev.** On the Two Versions of the Arthavistara-Sūtra in the Mongolian Kanjur ..... 35
- Igor A. Alimov.** «Dong Jing Meng Hua Lu»: Preface..... 44

### ARCHIVES OF MONGOLIAN STUDIES

- Liqiu Liu, Ramil M. Valeev, Rafael M. Valeev, Roza Z. Valeeva, Svetlana A. Kirillina.** Letters of V. A. Gordlevsky to Academician V. V. Bartold in the 1910–1920s From the Funds of the St. Petersburg Branch of the Archive of the Russian Academy of Sciences..... 50
- Agvaantseren Mandirmaa.** Mongolian Studies at the Oriental Institute: Some Archival Documents..... 64

### RELATED DISCIPLINES

- E. V. Asalkhanova.** I International Russian-Mongolian Plein Air “Drawing on Onon” ..... 73
- Konstantin A. Beketov, Natalya K. Beketova, Kh. Damdinsuren.** “The roads of N. K. Roerich”: the expedition of St. Petersburg Ilya Repin Academy of arts to Mongolia (continuation)..... 82

### REVIEWS

- Ekaterina V. Asalkhanova.** Interregional Academic and Practical Conference “Buryat Heroic Epic ‘Geser’. From the Past to the Future” (Ust-Ordynsky Settlement, Irkutsk Oblast, May 17, 2024) ..... 104
- Tatiana V. Ermakova.** The 16 th Conference “Current Issues of Buddhological and Indological Studies” (St. Petersburg, March 25, 2024)..... 114

Энхтайваны Гансүх  
Монгол Улсын Соёл урлагийн их сургууль

## МОНГОЛ ДАНЖУУР СУДАРТ БУЙ ТЭНГЭР, ГАЗРЫН ОРНЫ ЯЗГУУРТ МОРИЙГ ШИНЖИН ТАНИХ, ДҮРСЛЭЛИЙГ ТО- ДОРХОЙЛОХ НЬ

Нэн эртнээс эхлээд эдүгээ цаг үед олон сайхан бүтээлд монгол морины дүр дүрс олонтоо таардаг билээ. Монгол морьдын хөдөлгөөн, ааш зан, зүс, галбир төрхийн дүрсүүдийг сегментчлэх аргаар ангилах хэрэгтэй байна. Судлаач бидний хувьд эхлээд морины галбир төрхийг 3 ангилах боломжтой хэмээн үзлээ. Бидний илрүүлсэн монгол бичгээр бичигдсэн 30 гаруй судар сурвалжийн нэг болох “Монгол Даанжуур”-ын 219-р ботийн “Морины насны шастир” хэмээх судрын эх сурвалжид тулгуурлан семиотикийн арга зүйгээр “Тэнгэрийн орны морь”, “Газрын орны морь”, “Хан язгуурт хүлэг”, “Ноёлог язгуурт хүлэг” хэмээх орон, язгуур-ын хүлэг морийг ямар дүрстэй байх талаар дурдсан судалгааг хийлээ. Мөн “Тэнгэрийн орны морь”, “Газрын орны морь”-той холбоо үгээр олонтоо таарах яг энэ гээгүй ч “Завсрын орны морь” байж болох юм хэмээн үзэж дүрсэлсэн болно. Сурвалжид дурдсан үгийн давтамжийг түүвэрлэн, монгол бичгийг галиглан бичиж, мөн орчин цагийн монгол хэлэнд хөрвүүлэн судалгаандаа ашиглав. Мөн “Тэнгэрийн орны морь, Хан язгуурт хүлэг”, “Газрын орны морь, Ноёлог язгуурт хүлэг”-ийн ааш зан болох хатирч явахад үзүүлэх хөдөлгөөнийг дүрсэлсэн болно. Морины зураг дүрслэлийг ерөнхий хэлбэр төрхөөр нь “Тэнгэрийн орны морь”, “Газрын орны морь”, “Завсрын орны морь” хэмээн 3 ангилах боломжтой гэж үзэж байна.

Түлхүүр үг: Монгол морины язгуур, Морины насны шастир, Данжуур 219-р боть, Тэнгэрийн орны морь, Газрын орны морь

Зохиолчийн тухай: Энхтайваны Гансүх, докторант, Монгол Улсын Соёл урлагийн их сургууль (Монгол Улс, Улаанбаатар) (gansukh24@yahoo.com).

© Гансүх Э., 2024

Монголын дүрслэх урлаг, дизайны бүтээлүүдэд монгол морины олон янзын дүр дүрслэл олонтоо таардаг ч шинжлэх ухааны үндэслэлтэйгээр ямар нэгэн ангилалд оруулж судлаагүй байна. Цаашид бид бүхэн монгол морины дүр дүрслэлийг ангилахын тулд эрт үеийн түүх, олон судар сурвалжийг судлан үзэх шаардлагатай бөгөөд энэхүү өгүүлэлдээ зөвхөн нэг л сударт хийсэн судалгааны үр дүнг танилцуулж байна.

Монгол данжуур сударт буй тэнгэр, газрын орны язгуурт морийг шинжин таних, дүрслэлийг семиотикийн арга зүйгээр тодорхойлсон болно. Сурвалжид дурдсан үгийн давтамжийг түүвэрлэн монгол бичгийг галиглан бичиж, судалгаандаа ашиглалаа.

Монгол адуу нь морины шинжийн эртний сударт 100 гаруй жишил шинж төрхийг үзүүл-

дэг. Ер нь морины шинжийн судруудыг нэгтгэн эмхэтгэхэд орон, язгуур, махбод, чанарын ялгаг, жишил шинжийг таних арга билгийг монголчууд эрт үед зохиосон бололтой.

Монголчууд “Хүннү” гүрний үед эрийн 3 наадам хийж байсан түүх ч бий. Энэ л үеэс хурдан морины шинжийн нууц судар амнаас аманд дамжсаар бидэнд ирсэн байх.

“Монгол Даанжуур”-ын “Морины насны шастир” хэмээх сударт дурдсан “Тэнгэр, газрын орны морины тухай сурвалж дотор хэд хэдэн газар завсрын орны тухай гарсан билээ. Энэ нь “Тэнгэрийн орны морь”-ны ерөнхий хэлбэр галбир нь толгой дээр тэнгэрийн хаяа харах мэт, хөлөө жийн зогсох, нимгэн арьстай, дэл сүүл шингэн, хөнгөн явалтайгаар сурвалжид дурдагдсан. “Газрын орны морь” нь толгойгоороо газар шагайн, 4 хөлөө хумин зог-

сох хэмээсэн байдаг. Тэгэхээр “Завсрын орны морь”-ны толгой нь дээр ч биш мөн доор ч биш яг л завсраар нь буюу мундаа, хондлойн өндөртэй тэгш хэмд толгой байрлан, 4 хөл тэгш жигд зогсох буй заа [МДСҮ: 14а].

“Ганжуур”-ын тайлбар “Данжуур” 225 боть их хөлгөн судар товч тайлбар: “Монгол Даанжуур”<sup>1</sup>-ын 219-р ботид “МОРИНЫ НАСНЫ ШАСТИР” хэмээх судар буй. Энэ судар нь монгол бичгээр, шунхан бараар барласан судар юм. Энэ зохиол нь 8 ангитай бөгөөд анги тус бүр олон бүлэгтэй. Энэ судрыг Шалихотра гэгч \судрын зохиогч цаст<sup>2</sup>-ын умард зүгийн оронд сууж байсан цагт зохиов гэж бичсэн байна.

“Насны шастир”-ын анхны орон буюу 1-р ангиас бусад 7 анги нь адууны өвчнийг эмчлэх тухай байна. Энэ шастирын гарчиг нь “Морины шастир гарсан ёсыг үзүүлсэн 1-р бүлэг”, “Шавийг судлах хэмээгдэх 2-р бүлэг”, “Магад үгсийн хэмээгдэх 3-р бүлэг”,

<sup>1</sup> “Данжуур” гэдэг нь “Шастирын орчуулга” гэсэн төвд үг юм. Энэ нь эртний Энэтхэг, Төвөдийн эрдэмтэн бандида нарын их, бага арван ухааны орноор (Их таван ухаан: дотоод ухаан, урлахуй ухаан, учир шалтгааны ухаан, тэжээхүй ухаан, дуун ухаан. Бага таван ухаан: зурхай, зохист аялгуу, илт өгүүлэхүй, эвсүүлэн найруулахуй, дуурайн бүжиг) туурвисан 3400 гаруй зохиолыг эмхэтгэсэн том цоморлог болно.

“Данжуур”-г багтах их бага таван ухааны зохиолоос Төвөдийн хэлэнд IX зууны үеэс орчуулж эхлээд, XIV зууны үед тусгай цоморлог болгожээ. “Данжуур”-ын ном зохиолоос Монголчууд XIV зууны эхэн үеэс орчуулж, тайлбар судалгаа хийж байжээ.

Гэвч “Даанжуур”-ыг бүхэлд нь орчуулж хэвлэх ажлыг ХҮШ зууны тэргүүн хагаст Жанжаа хутагт Ролбийдоржийн удирдлагаар Монголын олон нутаг хошуунаас цугларсан 200 гаруй орчуулагч нар богино хугацаанд амжилттай хийж гүйцэтгэсэн юм.

“Данжуур”-ыг чухам орчуулж хэвлэх ажил 1742–1749 оны орчим хийсэн боловч, түүний бэлтгэл нэлээд өмнө эхэлсэн билээ. 1724 онд Данжуур-ыг орчуулах хааны зарлиг гарсан жилээс монголын олон хошуу нутгаас орчуулагч, барчин зэрэг хэвлэл, уран зохиолын хамаа бүхий хүмүүсийг зарлан цуглуулсан ажээ. Орчуулагч нарт аливаа ухааны нэр томъёог нэг мөр болгон орчуулахад хялбар дөхмийг бодож “Мэргэд гарахын орон” Төвд Монгол толь бичгийг 1748 онд хэвлэн гаргасан байна. “Данжуур”-ыг орчуулахад энэ мэт бэлтгэл ажлыг сайтар базаасны хүчинд уг зохиолыг цөөн жилийх дотор амжилттай орчуулж дуусгажээ [Чоймаа, 2017. Х. 284–289].

<sup>2</sup> Нэрт эрдэмтэн, доктор Х. Лувсанбалдан нь “Цастын орон гэдэг нь бол төвд орон бүгд түүнээс хойш орших нүүдэлчин Монголчууд дотор одоо зохиогдсон байж болзошгүй” хэмээн өгүүлжээ [Лувсанбалдан, 1989. Х. 4].

“Морины гарсан ёсон хэмээгдэх 4-р бүлэг”, “Умайд тогтох хэмээгдэх 5-р бүлэг”, “Морины чанарын 6-р бүлэг”, “Морины төрөл орны 7-р бүлэг”, “Морины 4 язгуурын 8-р бүлэг”, “Бэлгэ чанар 9-р бүлэг”, “Ухуулагдахууныг (эрхтнийг) номлосон 10-р бүлэг”, Хэмжээг үлэхийн (хэмжихийн) 11-р бүлэг”, “Арван гишүүний хувь ялгалын 12-р бүлэг”, “Гоо хийгээд гоо бусыг сайтар ялгахын 13-р бүлэг”, “Хэмжээний 14-р бүлэг”, “Идээний найрлын 15-р бүлэг”, “Үзэсгэлэнгийн 16-р бүлэг”, “Бэлгийн 17-р бүлэг”, “Өнгийг мэдэн үйлдэхийн 18-р бүлэг”, “Халзан хийгээд сарыг шинжлэхийн 19-р бүлэг”, “Цоохрын сайн мууг шинжлэхийн 20-р бүлэг”, “Загал өнгийн ялгал хэмээх 21-р бүлэг”, “Хааны хүлэглэх морины бэлгэ чанарын 22-р бүлэг”, “Холимгийн 23-р бүлэг”, “Нүд шинжлэхийн 24-р бүлэг”, “Шүд шинжлэхийн 25-р бүлэг”, “Эргүүлгийн 26-р бүлэг”, “Насны хэмжээ шинжлэх 27-р бүлэг”, “Нас мэдэн үйлдэхийн 28-р бүлэг”, “Үнэрийг шинжлэхийн 29-р бүлэг”, “Цууриа шинжлэхийн 30-р бүлэг”, “Алхдалын сайн мууг мэдэх 31-р бүлэг”, “Бие өсөхийн 32-р бүлэг”, “Гүйдэл шинжлэхийн 33-р бүлэг”, “Сортыг шинжлэхийн 34-р бүлэг”, “Их гэмийг шинжлэхийн 35-р бүлэг”, “Баатар хүчнийг шинжлэхийн 36-р бүлэг”, “Сүр жавхлан шинжлэхийн 37-р бүлэг”, “Язгуур шинжлэхийн 38-р бүлэг”, “Дахлай хэмээхийн 39-р бүлэг”, “Худалдаж авахыг шинжлэх 40-р бүлэг” хэмээх 40 бүлэгт хуваан зохигдсон [Лувсанбалдан, 1989. Х. 6, 7].

“МОРИНЫ НАСНЫ ШАСТИР” хэмээх судрын 32-р бүлэгт “Орноос, язгуураар шинжлэх” хэмээх тусгайлсан хэсэг байдаг. “МОРИНЫ НАСНЫ ШАСТИР” хэмээх сударт хамаарал бүхий морь, хүлэг, хөлөг, тэнгэр, тэнгэрийн орон, газар, газрын орон, язгуур, жигүүртэн, шувуу, гөрөөсөн, араатан, арслан хэмээх үгийг давтамжийн аргачлалаар илрүүлэхэд морь 177, хүлэг 22, хөлөг 21, тэнгэр 101, газар 55, язгуур 107, жигүүртэн 2, шувуу 30, гөрөөсөн 7, арслан 10 гэсэн илэрц байна. Иймд үгийн давтамж, сонгомол эхийн тайлал зэргээс харахад хамгийн олон илэрсэн үг болох “Тэнгэрийн орны морь”, “Газрын орны морь” гэсэн холбоо үгийг тэргүүн бүлэг хэмээн үзнэ.

“Хан<sup>3</sup> язгуурт” нь бол бусад сударт буй “Шувуун язгуурт хүлэг”, “Ноёлог<sup>4</sup> язгуурт” нь “Араатан язгуурт хүлэг” хэмээн дундад үеийн монголын судар сурвалжид давтагдаж байна. Монголд хурдан морины тухай бичигдсэн олон судар байдаг. “Хурдан морины шинж”, “Нууцаас нууц, далдаас далдын шулуун журамт”, “Дээд богдын хүлэг морин эрдэнийн шинж хийгээд эрхт бурхны хүлэг болсон эр сайн хүний хүслийг хангагч эрдэнэт 11 морины шинж ба жич бас морины шинж заслын бичиг сэлт хамт оршвой” гэх мэт олон их сурвалж буй. Бид энэ удаа зөвхөн “Монгол Даанжуур”-ын 219-р ботийн “МОРИНЫ НАСНЫ ШАСТИР” хэмээх сударт дурдсан “Тэнгэр, Газар, Хан, Ноёлог” хэмээх орон, язгуурын хүлэг морийг ямар дүртэй байх талаар дурдсан судалгааг хийлээ.

**1. Тэнгэрийн орны морь нь:** Энэ орны морийг олон судар сурвалжид дурдсанаар харахад “сэтгэл бээр амь баригчийн хийг хөдөлгөн бие махбодын тэргүүтэй олон үйл хөдөлгөөнийг удирдах мэт” гэх нь хүний сэтгэл “хийморь”-ийг сэргээдэг гэжээ.

11а. “*tegri-yin orun-dur törükü boluyu, öglige ögtegsen morin çu, amitan-u degedü bolqu bui*”. Тэнгэрийн оронд төрөх больюу, өглөг өгтсөн морь ч, амьтны дээд болох буй хэмээх нь ихэнхдээ шашны талаас тайлбар их байдаг ч үнэндээ энэ нь сайн эр хүний хүслийг хангагч эрдэнэт хүлэг эргэн төрөх тухай юм.

67а. “*Aliba ulaхан önggetü morin-u köl köke, sir-a çахан kiged qar-a, esebesü dorur-a köke ba sir-a kiged ulaхан ba çахан kiged qar-a qoyar öngge buyu rurban ba dörben öngge ba öngge-yin orum bui arсан, tegri-yin morin tere metü bolumu...*” Аливаа улаан өнгөт морь<sup>5</sup>-ны хөл хөх, шар, цагаан хийгээд хар. Эсвээс доор хөх ба шар хийгээд улаан ба цагаан хийгээд хар хоёр өнгө буюу гурван ба дөрвөн өнгө ба өнгийн ором буй агсан. Тэнгэрийн морин тэр мэт болмуй... Энэ нь нэг моринд 3-аас дээш өнгө орсон тухай бөгөөд их биеийн өнгө (зүс) улаан гэх нь хээр зүс, магадгүй улаан өнгөний бэлгэдэл, мөн “дарангуйлал, түрэмгийлэл, уур хилэнтэй гэх мэ-

<sup>3</sup> хан I. ~ гарди.

<sup>4</sup> ноёлог ~ ноёрхуу зан.

<sup>5</sup> Улаан өнгөт морь нь зэсэн улаан өнгө буюу зээрд, хээр зүс болой.

тээр араншинг бэлгэдэх нь ч бий. Тэнгэрийн морин тэр мэт болмуй хэмээжээ.

69б. “*Alimad busud bügüde ügei boluxad, orui anu batu-yin arban-luxa tegülдер qaxan-u kölgendiür jokistu ma-a li ke - luxa adali nidütü masi çaxan tosulirönggetü tegün-I sir-a tegri-yin morin kemeyü. qaxan tegün-tür kölegelesü çajar tegri-yi erke-ber bolxyu...*” Алимад<sup>6</sup> бусад бүгд үгүй болоод орой нь батын арав лугаа төгөлдөр хааны хүлгэн зохист Ма А Ли Хэ лугаа адил нүдэт маш цагаан тослог өнгөт түүнийг шар тэнгэрийн морь хэмээюү. Хаан түүнд хөлөглөвөөс газар тэнгэрийг эрхээр болгою.

**Шувуу буюу хан язгуурт:** хүлэг нь шувуу жиргэх мэт дуутай, толгой дээгүүр явдалтай, арьсан нимгэн, хойд 2 хөлөө жийж сайтар гишгэн зогсдог.

30б. “*Qan ijagur kiling-ün yosu-tu böged, esru-a-yin öngge tegulder kemen medegdeküi, törülki qorça boluxad baratur ba durjiginatala ingçaxaqu ba mörü inu beki boluxad yeke baratur, törülkin arixun boluxad yabudal çu sayiqan tegülдер ba gesigün delgegüi boluxad arisun nimgen, yabudal arixun boluxad nomuqan ba ayultan-aca üli ayuxçi, usun kiged gal ba luu-yin darun kiged yeke darun darurisgaqui-dur unaqu ba qalarun serigün-e kürelçeküi ba serigün çajar modun-u oi sirui ba qola yabuqu ba qabçal jam alimad-aça ulu ayuqu. Yeke çaxan-u çixulxan ba qongq-a kögim-ün darun-nuxud ba jokilduqui darun çarqui ba busu morin ingçaxaqu ba labai kiged yeke gegürge-yin darun ba kögim-ün darun kiged morazi-yin darun, sigür ba dhobaja-yin banjid-aça üli örgөгçi degedü morin bui. Del segul-iyen sayitur songçaju, bayasqui sedkil-iyer ingçaxaqu ba qoyar köl-I çajar deger-e sayitur giskigseger kü ingçaxaqu...*” Хан язгуур хилэнгийн ёст бөгөөд эсрүвагийн өнгө төгөлдөр хэмээн мэдэгдэхүй төрөлх хорч болоод баатар ба дуржигнатал янцгаах ба мөр нь бэх болоод их баатар төрөлх ариун болоод явдал ч сайхан төгөлдөр ба гишүүн дэлгүү болоод арьсан нимгэн, явдал ариун болоод номхон ба аюултнаас үл айгч усан хийгээд гал ба луугийн дуун хийгээд их дуун дуурсахуйд унах ба халуун сэрүүн хүрэлцэхүй ба сэрүүн газар модны ой шугуй ба хол явах ба хавцал зам алимадаас үл айх их зааны чуулган

<sup>6</sup> Алимад ~ аль, аливаа.

ба хонх хөгжмийн дуунууд ба зохилдохуй дуун гархуй ба бус морин янцгаах ба лавай хийгээд их хөөргийн дуун ба хөгжмийн дуун хийгээд моразын дуун шүүр ба джобагийн банжидаас үл өргөгч дээд морин буй. Дэл сүүлээ сайтар сонгож баясахуй сэтгэлээр янцгаах ба хоёр хөлийг газар дээр сайтар гишгэсээр хө янцгаах...

31a. *“sungxaju uqurqu ba ečüs-I küčütei-ber uqurqu ba busu morin-I jaruqu kiged baiyildurandur mori-tu kiged jaxan-tu ba terge-tü yabaxan dörben ayimax čerig-I darugči ba darui-dur jögelen darun-iyar qotala жүг түгемел ингчааау ба busu morin nurud tegün-ü yabudal-dur ülü dasumui. Mese-dür qatqurdabacu ebečün öčüken boluxad mesen-I üjebesu ülü ayuqu, yabudal türgen boluxad bagatur ba bayilduqui čag-tur cinadus-I türgen-e daruči, nidün inücindamani metü sir-a, sayin öngge-tü oyun tegülder tegünčilen qurdun ba sidurru boluxad sintaral-ugei yeke küčütü, nasuda qamuxüyiles-I čidarči ba nasuda seremjitu nisvanis ügei, buyan üyiledkui čečeg tosun-u ür-e tegüsügsen ünür bui boluxad tegri kiged gandariyin baratur küčütü, tegün-lüge adali yabudal visai tegülder, buyan-tu boluxad maxad yabudal-tu morin tegün-I qan ijaxur-tu kemen medegdeküi...”* Сунгаж ухрах ба, эцсийг хүчтэйгээр ухрах ба, бус морийг зуух хийгээд, байлдаанд морьт хийгээд, заант ба, тэргэт завхан дөрвөн аймаг цэргийг дарагч ба, даруйд зөөлөн дуугаар хотол зүг түгээмэл янцгаах ба бус моринууд түүний явдалд үл дасмуй, мэсэнд хатгагдавч өвчин өчүүхэн болоод, мэсийг үзвээс үл айх, явдал түргэн болоод баатар ба, байлдхуй цагт чагтасыг түргэнээ дарагч, нүд нь чандмань мэт шар, сайн өнгөт оюун төгөлдөр түүнчлэн хурдан ба, шудраг болоод шантрал үгүй их хүчит, насад хамаг үйлсийг чадагч ба, насад сэрэмжит нисваанис үгүй, буян үйлдэхүй цэцэг тосны үр төгссөн нуур буй болоод, тэнгэр хийгээд гадрын баатар хүчит, түүнтэй адил явдал жишээ төгөлдөр, буянт болоод магад явдалт, морь түүнийг хан язгуурт хэмээн мэдэгдэхүй...

Нар, сар мэт тодорхой буй. Арслан харайсан мэт, цээж сайн, урд хөл урт, толгой өндөр, хамар их, хошуу чимх мэт шулуун, нуруу шулуун ирмэгтэй хурц, зөөлөн амтай мөн шувуу буюу хан язгуурт хүлгийн дэл сүүл шингэн, арьсан нимгэн, хойд 2 хөлөө жийж сайтар гишгэн зог-

сох зэрэг нь энэ орон, язгуур нэг буй [МДСҮ: 306]. Тэнгэрийн орны морь нь ус, усан махбодын талаар их дурдагдаж байгаа нь монголын олон сурвалжтай адил бичигдсэн байна. (Зураг 1.)

**2. Газрын орны морь:** Энэ орны морийг данжуурт *“Цастын орноос умард зүгт, түүнд алимад төрсөн элдэв зүйл, гарахуйн орноос болсон, дээд явдал лугаа хэмээюү”* Энэ цастын орноос умард гэдэг нь Төвөдөөс хойш тал нутагт төрсөн унага нь хамгийн хурдан морийг хэлнэ хэмээсэн бололтой.

14a. *“erte čax-tur morin-i qubilxarsan-iyar, tegünčilen xajar tegri-e yubuqu kiged, gegen javsar xajar door-a yubuqu kiged, ulu yabuqun alimad ba, ab ali amitan-nurud, tedeger бүгүде-йи ilete qubilxarsan bolai...”* Эрт цагт морийг хувилгаснаар, түүнчлэн газар тэнгэрт явах хийгээд, гэгээн завсар газар доор явах хийгээд, үл явах алимад ба, ав аль амьтан нугууд, тэдгээр бүгдийг илт хувилгасан болой...

94b. *“alimad nasuda xajar qaraxči-yi anu бүкүгер toluxai-tu kemene, tasixur oruxulbasu axurlaqui ber...”* Алимад насад газар харагчийг нь бүхээр толгойт хэмээнэ, ташуур оруулбаас уурлахуй бээр... хэмээх нь газар харагч гэдэг нь хүзүү дор духайж зогсох мөн ташуурдахад лазандуу, хошуугаараа газар хүрэх мэт явдаг тухай дурджээ.

95a. *“čike-ben solbin axulugci, tegün-I tegsi busu čiketü kemeyü”* Чихээ солбин агуулагч<sup>7</sup>, түүнийг тэгш бус чихт хэмээюү. Энэ нь эзнээ хараад чихээ солбих, магадгүй хулмайн зогсох тухай дүрсэлсэн бололтой.


95a. *“Tasigur terigüten nigen-iyer ču ebedkel-ügei tasixurdaqui-dur ber axurlan uridu qoyar kol-iyer gajar maltaxči kemen nomlajuqui. axurlaxsan-iyar sidü-ben qabiruxči-yi sidiün-iyen qabiruxči kemen nomlabai...”* Ташуур тэргүүтэн нэгнээр ч өвтгөлгүй ташуурдахуйд бээр уурлан урд хоёр хөлөөр газар малтагч хэмээн номложухуй<sup>8</sup>. Уурласнаар шүдээ хавирагчийг шүдээ хавирагч хэмээн номловой...

**Араатан буюу ноёлог язгуурт:** Хүлэг эртний зарим сударт харгам сайтай гэсэн байдаг. Энэ нь харгам овоо буюу олон ясны уулзах юм.

<sup>7</sup> Агуулагч ~ агуулах үйлийн эзэн.

<sup>8</sup> Номложухуй~номыг сэнхрүүлэн мэдүүлэх, учир чанарыг ухуулан сургах.





Зураг 1. Тэнгэрийн орны морь


Харгам сайтай, хошуу урттай морийг дайны хуягт сайн тул, тулгуур сайтай гэж үздэг байжээ. Араатан гэхийн учир адуу адуун дотроос соёо урттай, дайн тулаанд хазах үйлдэл хийдэг байх магадлалтай.

31a. “*noyalix ijaarur-tu umdaran-dur bayasun batu amurlingxui boluxad oyun yeke yalxux-tu, ulu kimuran ülü bayasqu, üneker nomuqan ybudal tegülder, axur-ügei bolugad omug-ügei, nomuqan boluxad jim-a...*” Ноёлог язгуурт ундаанд баясан бат, амарлингуй болоод оюун их үл хямран үл баясах, үнэхээр номхон явдал төгөлдөр, нуур үгүй болоод омог үгүй, номхон болоод жам.

31b. “*Yosun tegsi ba, ebečin kiged qalarun ba umdar-a dasuxči, ačiy-a acin jam-dur yabuquy-a-da batu, tegün-I qurdun qasing kiritei bui. Bayidal kiged bey-e küčün dumda böged, nidün köke kiged tegünčilen sir-a ba qar-a kiged duru-a-yin öngge metü ba çayibur köke usun-u öngge çaran ba kömüsge inü da la-yin öngge metü ba olangki qalarun-u öngge metü boluxad deger-e door-a tusburi yeke busu çegeji inü yeke bolai. Ha ri nu ke tegünčilen ku, temegen-u sun-u ünür-lüge tegülder seremji öčüken noyir anu*

*yeke ba kümün-ü bagatur küčün-dür sitügči, tegüs küliçel-tu tere metü yabudal-tu morin-I inü noyalix ijaarur-tu kememüi...*” Ёсон тэгш ба, өвчин хийгээд халуун ба ундаанаа дасагч, ачаа ачин замд явахуйд бат, түүнийг хурдан хашин хиртэй буй, байдал хийгээд бие хүч дунд бүгд, нүд хөх хийгээд түүнчлэн шар ба хар хийгээд дурын өнгө мэт ба, цайвар хөх усны өнгө цагаан ба, хөмсөг нь дарлагын өнгө мэт ба, олонх халууны өнгө мэт болоод, дээр доор тус бүр их бус, цээж нь их болой, түүнчлэн, тэмээний сүүний үнэр лүгээ төгөлдөр сэрэмж өчүүхэн, нойр их ба, хүний баатар хүчинд шүтэгч, төгс хүлцэлт тэр мэт явдалт морийг нь ноёлог язгуур хэмээмүй...

Мэлхий мэт ягалгар дөрвөлжин их нүдтэй, магнай агуу, хоншоор хошуу монхор, уруул ам их, нуруу хавтгай, зооны мах ихтэй, дөрвөлжин, хөл богино, номхон хашин, хатуу амтай гэж сурвалжид заажээ [МДСҢ: 946, 31a]. Мөн энэ моринд гал махбодын талаар орсон байдаг. Магадгүй гал махбод нь хат ихтэй байж болох юм. Тийм морь ус чийгт муу явдаг талаар олон сударт дурдсан байдаг. (Зураг 2.)



Зураг 2. Газрын орны морь

**3. Завсрын орны морь нь:** Солонго мэт үзэсгэлэнтэй, сэтгэлд тааламжтай буй хэмээн морины шинжийн ихэнх судруудад бичээстэй байна. Бидний төсөөллөөр завсрын орны морь нь тэнгэр, газрын адууны дундаж төрх, шинжтэй буюу эрлийз аргамгийн дүр зурагтай дүйцэн ирж байна. “*дорно оршихуй мөрнөөс, түүний хүч хийгээд сүр өнгө тэргүүтний хэмжээгээр дундаж хэмээмү, тоост газархийгээд хавчиг уул, сүрт бие тэргүүтний морийг өнгө зүс хүчин хийгээд биеийн хэмжээ, баатар хүчийг дурьд хэмээн мэдэгдэхүй*” [МДСҮ: 1086] Завсрын орны хүлэг нь салхи уруудан хөнтөргөн замд хуйлран давхихдаа онцгой сайн хэмээн тооцож байна. (Зураг 3.)

Монголчуудын эртний дүрслэх урлаг дахь морины зураг хайхад Рашид-ад-Дины “Судрын чуулган”<sup>9</sup>, Дундад Мин гүрний үед Жао Мэн-Фу<sup>10</sup> нарын уран бүтээлтэй

<sup>9</sup> Энэ зохиолыг Персийн эмч, эрдэмтэн Рашид ад-Дин тэргүүтэй эрдэмтэд бичжээ. “Судрын чуулган”-д Чингис хаан болон түүний удмынхны түүх голлон бичигдсэн бөгөөд монголчуудын захиргаанд орсон олон нүүдэлчин аймгийн түүх мөн бичигдсэн байдаг.

<sup>10</sup> Юань гүрний алба хааж байсан дундад Мин гүрний үеийн Жао Мэн-Фу, Хуан Гун-Ван, Ван Мэн, У Жэнь нар Юань зургийн дөрвөн их мастерын нэг гэдгээрээ алдартай байв.


зайлшгүй холбогддог билээ. Нэгэн цаг үе болох Юань гүрний үед амьдарч байсан уран бүтээлчдийн 2 бүтээлийн зургууд монголчууд бидэнд их тархжээ. Энэхүү 2 зургийн морь дүрслэл нь тэнгэр, газар мэт ялгаатай зурагдсан байдаг.

Бид бүхний судалгаагаар Рашид-ад-Дины 1306–1311 онд зохиогдсон Судрын чуулганы түүхэн зохиолын чимэглэлийн зураг болох 22×26.2 см хэмжээтэй цаас дээр шороон будгаар “Монгол язгууртан бараа бологсдын хамт” хэмээх зураг нь “Тэнгэрийн орны, Шувуу буюу хан язгуурт хүлэг”-ийн дүрслэлийг санагдам дүрсэлжээ. (Зураг 4.)

Юань гүрний үеийн уран зураач Жао Мэнфу зураачийн 1271–1368 онд 22.7×49 см хэмжээтэй муутуу цаасан дээр харбэхээр “Монгол морин зураг” нь “Газрын орны, Араатан буюу ноёлог язгуурт хүлэг”-ийн дүрслэлтэй таарч байна. (Зураг 5.)

Тэнгэрийн орны, хан язгуурт хүлэг гэгч нь юлган<sup>11</sup> шударга явдалтай, наадмын газарт санаа бяцхан аймтгай, хөлөө дээр өргөж явах, хүзүүний тавил өндөр босоодуу тэмээний хүзүүтэй төстэй. Толгой их дээр


<sup>11</sup> Юлган~морины зөөлөн хөнгөн явдал.



Зураг 3. Завсрын орны хүлэг



Зураг 4. “Монгол язгууртан бараа бологсдын хамт” Рашид-ад-Дини “Судрын чуулган” түүхэн зохиол (1306–1311), 22 × 26.2 см, цаас, шороо будаг



Зураг 5. Жао Мэнфу. “Монгол морин зураг” 1271–1368, 22.7 × 49см, муутуу цаасан, бэх

явдаг, урт согоон чихтэй, цээж сэрвээ өндөр, бие уртлаг, хөл урт, цээжин биеэр зүтгэж давхидаг. (Зураг 6.)


Газрын орны, араатан буюу ноёлог язгуурт хүлэг гэгч хашин, нүд улаан түргэн амьсгалах, толгой доор, шээхдээ хөлөө их өргөх, амаа ангайх, аймтгайгүй баатар хэмээсэн [МДСҢ: 31а, 31б]. (Зураг 7.) Бид морины шинжийн сургаалыг баримталж жишил дүйцлийг орон, язгуур тус бүрд нь шингээж дүрсэлсэн болно.

Эртний хадны сүг зургуудад тодорхой тусгагдсан төв азийн уугуул адууны төрхтэй дүйцсэн эдгээр шинж бэлгэ нь газрын орны морь нь жинхэнэ монгол адуу болохыг нотолно хэмээн бид үзэж байна.


Тухайн орон, язгуурын хүлгийн шинжийндүйцэлзүйрлэлньнэгээснөгөөд дамжин шилжих хэлбэрт оршиж байгаа нь бидний судалгаагаар ажиглагдлаа. Энэхүү зүй тогтлын үндсэн бүлэг нь орон, удаах дэд бүлэгт язгуураар ангилагдаж байна. Язгуурын зохилдлоготой уялдан хүлгийн шинжийн дүйцэл нь завсрын олон дүр төрхийг үзүүлэн хурдан морины олон хэлбэртэй жишил шинжүүд үүсэж байна аа.

Нүүдэлчин монголчууд хүлгийг шинжин таних, уяж сойх, анагаах зэрэг нууцын нууц, мэдээ, мэдээллээ амнаас чихэнд гэсэн бичигдээгүй хуулиар дамжуулан цээжлүүлдэг байсан байх магадлалтай байна. Монголч эрдэмтэд VI–VIII зуунд монгол бичгийг дам авсан гэдэгт илүүтэй санал нэгдсэн байдаг. Одоогоор хурдан морины судар сурвалжийг дагнан судалсан эх бичиг судлаач байхгүй байна. Үүнийг дахин лавшруулан судлууштай болно. Одоогоор хурдан морины тухай монгол бичгээр, одоогоор олдлоод байгаа 30 гаруй судар сурвалж байна. Бидэнэудаа 1742–1749 онд орчуулагдсан “Монгол данжуурын” 219-р ботийн “Морины насны шастир” хэмээх сударт буй “Тэнгэр, Газарын орны морь”, “Шувуу буюу Хан язгуурт, Араатан буюу Ноёлог язгуурт” хүлгийн дүрсийг шинжин танин, дүрслэлийг тодорхойлон судаллаа.

“Тэнгэрийн орны, Шувуу буюу хан язгуурт хүлэг” нь арслан харайсан мэт урт цээжтэй, урд хөл урт, толгой өндөр, хамар их, хошуу чимх мэт шулуун, нуруу шулуун хурц ирмэгтэй, дэл сүүл шингэн, хойд 2 хөлөө жийн сайтар гишгэн зогсох зэрэг нь



Зураг 6. Хан язгуурт хүлэг



Зураг 7. Ноёлог язгуурт хүлэг

1-р зурагт дүрсэлсэн болно. “Газрын орны, Араатан буюу ноёлог язгуурт хүлэг”-ийг ягалгар дөрвөлжин биетэй, мэлхий нүдтэй, магнай агуу, хоншоор хошуу монхор, уруул ам их, нуруу бөгтөр, зооны мах ихтэй, 4 хөл богино хумьж зогсдог хүлгийг 2-р зурагт зурж дүрсэлсэн.

“Тэнгэрийн орны морь”-ийг хамгийн энгийнээр ялгах боломж нь морины толгой нь тэнгэрийн хаяа ширтсэн мэт шулуун хардаг. Мөн тэнгэрт ойрхон толгойтой гэдгээр ч ялгах боломжтой. Дөрвөн хөлөө гадагш нь жийн зогсдог. “Газрын орны морь”-ны толгой нь газар шагайн духайн,

дөрвөн хөлөө хумин зогсдог. Газар морины толгой их өвөрмөц түүшүү шанаа их, хоншоор монхор, уруул ам их, хөвч татан нум мэт нумран зогсдог. “Завсрын орны морь”-ны толгой тэнгэр, газрын завсрын дунд толгой байрлана. Их биеийн хат дунд зэрэг тэгш, өөд, уруу алинд ч сайн давхидаг. Бид бүхний дүрсэлсэн морьдын зургаар “Тэнгэрийн орны морь”, “Газрын орны морь”, “Завсрын орны морь” гэж 3 ангилан цаашид дүрслэх урлаг болон дизайн, урлаг судлалд ашиглах боломжтой гэж бид үзэж байна.

## АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

МД: Монгол Данжуур.

МДС: Монгол Данжуур судар.

Баянбат, 2016: *Баянбат Д.* Монгол адууны нэвтрэхий толь [Mongolian Horse Encyclopedia]. Б. I, II. Улаанбаатар, 2016.

Лувсанбалдан, 1989: *Лувсанбалдан Х.* Хүлгийн шинж [Lip Profile]. Улаанбаатар, 1989.

Чоймаа, 1998: *Чоймаа Ш.* Монголын Нууц Товчоон-д гарах “külüg” хэмээх үгийн утга, гарал

хувьсал [The Meaning and Evolution of the Word “külüg” in the Mongolian Secret Brief History] // Journal of Inner Mongolia University (Philosophy and Social Sciences in Mongolian), Köke qota, 1998.

Чоймаа, 2017: *Чоймаа Ш.* Монгол хэл, бичиг, соёл судлал [Mongolian language, literature and cultural studies] // Эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган II. Улаанбаатар, 2017.

## CHARACTERISTICS AND DESCRIPTIONS OF SKY AND LAND-DERIVED HORSES IN DANJUUR SUTRA

Enkhtaivany GANSUKH  
University of Mongolian Culture and Art

Mongolian Horse characters and figures have been described in many works since very ancient time. Mongolian horse motions, characters, suits and silhouettes are required to be divided by the segmentation technique. We, researchers consider that the Mongolian horse silhouettes can be classified into three parts. Research on the determination of silhouettes of the “Sky horses”, “Land horses”, “King horse” and “Leading horses” on the basis of the source named “Horse age book” included in the 219th book of Mongolian Danjuur and which is found among 30 works written in Mongolian old script. Moreover, we determined the silhouette of “Neutral zone horses” because this word combination is seen together with words as “Sky horses” and “Land horses” despite there is not any paragraphs about such horses. We inverted texts written in old Mongolian script into modern Mongolian words choosing repeated words to use for the research. In addition to it, we described the running ways of “Sky horses”, “Land horses”, “King horse” and “Leading horses” in different motions.

Key words: Mongolian horse characteristics, sky-derived horses, land-derived horses.

About the author: **Enkhtaivany GANSUKH**, Doctorant, University of Mongolian Culture and Art (Mongolia, Ulaanbaatar) (gansukh24@yahoo.com).